



ISSUE #6

30 September 2011

ЗАХИРЛЫН МЭДЭЭЛЭЛ

Сайн байцгаана уу,

Энэ сард бараг хур тунадас ороогүйд бид талархууштай. Лхагва гарагт цас орсоныг эс тооцвол манай спортын талбайн багийн ажил тасралтгүй явагдсаар байна.



10 сарын 7-ны Баасан гарагт 2:00 цагт бид шинэ талбайн нээлтийн ажиллагааг хийх болно. Бид та бүхнийг хүрэлцэн ирж манай талбайн нээлтийн ажиллагаанд оролцохыг урьж байна.

Тэмдэглэлт үйл явдал гэснээс манай сургуулийн хичээлийн жил эхлээд 40-д хонож байна. ОУДС-д шинээр ирсэн миний хувьд бараг өдөр бүр л тэмдэглэлт үйл явдал болж байна гэсэн үг. Бага, Дунд Сургуулийн ангиудаар орж хичээлийн явцтай танилцаж, сурагчдын зөвлөлийн хуралд сууж сурагчид хурлаа хэрхэн зохион байгуулж удирдах чадвараа хөгжүүлж байгааг харж, кафетерияд суугаад сайн хооллож баяр хөөрөөр дүүрэн байгаа сурагчдаа харж, биеийн тамирын зааланд үзэгчийн суудлаас волейболын тэмцээнд оролцож байгаа сурагчдынхаа тоглолтыг үзэж, өглөө бүр хичээлдээ яаран ирж бидэнтэй мэндчилж байгаа сурагчид эцэг эхчүүдээ харахад ч энэ бүхэн миний хувьд тэмдэглэх ёстой олон баярт үйл явдлууд байдаг.

ОУДС-ийн гол үндсэн бизнес бол сурагчдыг сургах. Энэ сургалтын үйл ажиллагаа аюулгүй, амар тайван, эерэг уур амьсгалтай орчинд л үр дүнтэй явагдах боломжтой. Би дээр хийсэн ажиглалтуудан дээрээ үндэслэж энэ сайн бат суурь манай сургуульд үнэхээр байдаг юм байна гэсэн дүгнэлт хийсэн. Бидэнд тэмдэглэх олон амжилт бүтээл байгаа ч цаашид анхаарах зүйлс бас бий. Бид энэ ололт амжилтаа цаашид бататгаж сайн ажиллах ёстой.



Энэ ажлыг сургуулийн баримтлах бодлого, зорилготой уялдуулж ажиллахын тулд сайтар ярилцаж төлөвлөх ёстой. Энэ ажилд их цаг хугацаа, уйгагүй хөдөлмөр зарцуулагдах болно.

Манай ажлын гол зарчим сургуулийн стратеги төлөвлөгөөний эрхэм зорилго, хэтийн төлөв, урианд тодорхой тусгагдсан. Долоо хоногийн дараа магадлан итгэмжлэлийн шалгалтын багийн хамт олон манай сургууль дээр айлчилж ирэх гэж байна. Үүний дараа бид Мэдээгээр дамжуулан таван жилийн стратеги төлөвлөгөөний зургаан үндсэн гол зорилтуудын талаар та бүхэнд дэлгэрэнгүй мэдээлэл өгөх болно.

THE MEEDEE

The Weekly Newsletter of the International School of Ulaanbaatar

ОУДС-ийн Эрхэмлэх Үнэт Зүйлс

ОУДС-ийн эрхэмлэх үнэт зүйлс нь бидний ажлын гол тулгуур үзэл баримтлал, бидний хариуцлагын гол шалгуур болж өгдөг. Бид дараах зүйлст итгэдэг:

- Сайн боловсрол нь сурагчдын онцгой авъяас, чадварт тулгуурлан тэднийг бүх талаар хөгжүүлэхэд чиглэгддэг.
- олон орны соёл заншилтай орчин нь дэлхийг өргөн хүрээнд харж сурагчид өөрсдийн ялгаатай талыг ойлгож үнэлж хүндлэх боломжийг олгодог.
- Сургалтын таатай орчин бүрдүүлсэнээр сурагчид нэг нэгнээ хүндэлж хувь хүний хувьд өөрөө хамт олныхоо нэг салшгүй хэсэг гэдгийг ойлгож нийтгэч байх зан чанараа хөгжүүлж чаддаг.
- тэнцвэртэй боловсрол нь аливаа сорилттой тулгарч амжилттай даван гарах арга зам, итгэлтэй байдал, хөшүүргийг сурагчдад олгодог бөгөөд цаашид амжилттай суралцахад нь чиглүүлж өгдөг.
- олон улсын сургууль нь тухайн орныхоо соёл заншил, өв уламжлалаар баяжиж байдаг бөгөөд сурагчдын сургалтын үйл явцад энэ нь чухал ач холбогдолтой байдаг.
- боловсрол олгох асуудал нь багш, эцэг эх, сурагчид, сургуулийн ажилтнуудаас бүрдсэн нийт хамт олны хамтарсан үүрэг хариуцлага байдаг.

Бидний Зорилго

Манай сургуулийн нэр хүнд ололт амжилт дэлхийн шилдэг боловсрол болох олон улсын баклавриатын байгууллагын хөтөлбөр дээр суурилсан бөгөөд энэхүү хөтөлбөрийг сурагч нэг бүрийн хэрэгцээнд тулгуурлан, туршлагатай мэргэжилтнүүд боловсруулан гаргасан. Бидний зорилго сургуулийн гол зорилтыг тодорхойлдог бөгөөд эрхэм зорилгоо хэрэгжүүлэх бидний ажлыг чиглүүлж өгдөг.

Зорилго- Даяарчлагдсан нийгэмд үнэтэй хувь нэмэр оруулах сурагчдадаа авъяас чадвараа хөгжүүлэхэд нь урам зориг өгөхийн төлөө бид бүх талаараа шилдэг нь байх ёстой.

- Сурагчдын онцгой авъяас чадвар, боломжийг хөгжүүлэн дэмжихийн сацуу тэдэнд дэлхийн шилдэг боловсролыг эзэмшүүлэх
- Соёл заншил, орчны ялгаатай байдлыг ойлгож хүндэтгэх үзлийг сурагчдад төлөвшүүлэх
- Сурагчдыг насан туршдаа суралцдаг, бүтээлчээр сэтгэдэг дэлхийн иргэн болгож бүх талаар нь хөгжүүлдэг шилдэг боловсролд хөрөнгө оруулалт хийснээр бид зорилгодоо хүрч чадна.

Бидний Эрхэм Зорилго

Манай эрхэм зорилго бидний цаашдын ирээдүйг болон ирэх таван жилд бид ямар амжилтанд хүрэхээр зорилго тавин ажиллаж байгааг тодорхойлдог.

Эрхэм Зорилго-Монгол орны өвөрмөц соёл, ёс заншил, өв уламжлалд тулгуурлан сурагчдыг цаашид амжилттай суралцах, ажил амьдралд нь бэлтгэхэд чиглэсэн дэлхийн шилдэг боловсролыг ОУДС олгоно.

БИДНИЙ УРИА

Эрдэм боловсролтой
Бусдын төлөөх зүрх сэтгэлтэй
Амжилт арвинтай байж
Өөрчлөлт Хийх сурагчдыг бид бэлтгэнэ.

Захирал Robert Stearns

ХУАНЛИД ТЭМДЭГЛЭХ ӨДРҮҮД:

10 сарын 8

ОУДС-ийн Хөл Бөмбөгийн Тэмцээн 11:00-17:00

10 сарын 9-14

Магадлан Итгэмжлэлийн Шалгалтын багийн айлчлал IBO/CIS/NEASC

10 сарын 17-25

Сурагчдын Намрын Амралт

10 сарын 24,25

Багш нарын Мэргэжил Дээшлүүлэх Өдөр

ДУНД СУРГУУЛИЙН МЭДЭЭ

Цаг агаар өөрчлөгдөж цас орсон ч ОУДС-ийн хувьд энэ долоо хоног амжилттай дуусч байна. Том ангийн сурагчид ч гэсэн даарах учраас та бүхэн хүүхдүүдээ цаг агаарт тохируулж дулаан хувцаслаарай.

Сургуулийн спорт тоглоомын талбай удахгүй ногоон зүлэгтэй болно. Талбай маань ногоон, улаан өнгөтэй болж бас сагсны шийдтэй болсоныг хараад бид баяртай байна. Энэ бүхнийг бидний төлөө зохион байгуулж хийлгэж өгсөн Сургуулийн Удирдах Зөвлөлд баярлалаа.

Ахлах сургуулийн аялагчдын клубын сурагчид маань хоногоор явган аялалд яваад ирсэн. Энэ амралтын өдрүүдээр дунд сургуулийн аялагчид маань Chris Cartwright-н хамт аялалд гарахаар төлөвлөж байна. Сурагчид маань явган аялал хийж цагийг хөгжөөнтэй өнгөрүүлнэ гэж би найдаж байна.

Амралтын өдрүүдээ ая тухтай өнгөрүүлээрэй!

Дунд Сургуулийн Эрхлэгч Betsy Hanselmann

Ахлах Сургуулийн Залуу Аялагчдын Клуб

ОУДС-ийн ахлах сургуулийн залуу аялагчдын клубын гишүүд хоёр өдрийн үүргэвчтэй явган аялал Богд Хан Ууланд хийлээ. Зайсангийн ард байрлах гэр кемпээс баруун тийш таван цаг явган алхаж Нүхтийн аманд ирлээ.



Сурагчид өөрсдийн хэрэгцээтэй зүйлсийг үүрч явганаар алхаж хоноглох газраа ирж оройн хоолоо бэлтгэсэн. Хоёр жилийн өмнөхийг бодвол сурагчдын хоол хийх чадвар сайжирч хоолны саваа төвөггүй цэвэрлэж байлаа. Түлэгдсэн будаа чанасан гахайн мах идэж байсныг бодоход үхрийн махтай гуляш хийсэн нь том өөрчлөлт байлаа.



Байгаль орчинд аль болох нөлөөлөхгүйгээр өөрсдөө бие дааж аялал хийх чадварыг сурагчдад эзэмшүүлэхэд манай аялалын гол зорилго оршдог. Зэрлэг онгон газрыг олж илрүүлэн хамгаалалтанд авсаны төлөө олгогддог John Muir-н шагналыг авахын төлөө бид жилийн турш мэрийж ажиллах болно. Манай сурагчид оролцож болох байгаль орчныг хамгаалах төслийн талаар та бүхэн мэдэж байвал багш Dave Chilton, Dave Lauchmen нартай дараах e-мэйл хаягаар холбогдоорой:

d.chilton@isumongolia.edu.mn

d.lauchmen@isumongolia.edu.mn

Хотуудын Тогтвортой хөгжил

9-р ангийн сурагчид Даваа гарагийн өглөө Баян Зүрх дүүргийн Цэцэглэх Ирээдүй төвд зочиллоо. Нийгмийн ухаан, Дизайн Технологийн хичээлийн «Хотуудын Тогтвортой Хөгжил» хам сэдвийн хүрээнд тэд мэдээлэл цуглуулах зорилготой байсан. Сурагчид гэрт амьдардаг айлуудаар орж нэг айлын амьдралтай танилцсаны үндсэн дээр бодит төсөв гаргаж үзлээ.

Цэцэглэх Ирээдүй төв нь олон жилийн турш үйл ажиллагаа явуулж байгаа ТББ бөгөөд ядуу өрхүүдийн цэцэрлэгийн насны хүүхдүүдэд боловсрол олгох, залуучуудад мэргэжлийн сургалт явуулах, хүнс, түлшээр хангах барилгын ажилд дэмжлэг үзүүлэх зэргээр олон төрлийн үйлчилгээ үзүүлдэг. Хэрвээ та бүхэн Цэцэглэх Ирээдүй төвөөр зочлох буюу энэ төвийн үйл ажиллагаанд оролцохыг хүсвэл Trov Trvdik-тэй rinkydinkadt@yahoo.com хаягаар холбоо барина уу.



David Chilton, Ken Vanderstoep



БАГА СУРГУУЛИЙН МЭДЭЭ

Бага Сургуулийн Жүжигчилсэн Тоглолт

Саяхан би Бага Сургуулийн сурагчдын 12 сард тоглох “Alice in Wonderland” жүжигт тоглох сурагчдын сонгон шалгаруулалтанд оролцлоо. Уг жүжгийн 25 дүрд тоглохоор 69 сурагч саналаа ирүүлжээ. Энэ бол манай сурагчид өөртөө итгэлтэй, зоригтой байгаагийн гайхамшигт жишээ юм!

Энэ жүжгийн нэг гол онцлог нь тоглолтын үеэр бага сургуулийн бүх 150 сурагч нэгэн зэрэг тайзан дээр гарч урлагийн авьяасаа бидэнд харуулах юм. Бага сургуулийн жүжигчилсэн тоглолт нь манай сургуулийн сурагчид тэнцвэрт боловсрол эзэмшиж байгаагийн нэг тод баталгаа болдог. Сурагчдын сонгон шалгаруулалтыг зохион байгуулж явуулсан багш Ms. Bailey-Summers, Ms. Sarantungaa and Mr. Kidson нар баяр хүргэе. Бид тоглолтыг удахгүй үзэхээр хүлээж байна!

Бага Сургуулийн Эрхлэгч Rick Elya